



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны  
хүрээнд хэрэгжүүлэх зарим төслийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 26/09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн оновчтой системийг хөгжүүлж, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, гэр хорооллын ахуй үйлчилгээг сайжруулах зорилгоор дор дурдсан төслүүдийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д үүрэг болгосугай. Үүнд:

1. “Ухаалаг төлбөрийн нэгдсэн систем” төсөл;
2. “Улаанбаатар хотын такси үйлчилгээг сайжруулах нь” төсөл;
3. “Нийтийн ахуй үйлчилгээний төв” төсөл;
4. “Улаанбаатар хотын авто зогсоолын менежментийг сайжруулах нь” төсөл;

2. Дээрх төслүүдийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар зохион байгуулж хэрэгжүүлэхийг “Улаанбаатар хөгжлийн корпораци” ХК /Ж.Билэгсайхан/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА



Р.ДАГВА

1110100482